



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 6/08

Ховд

Г Е.Уатханыг ажилд томилох тухай Г

Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 05/2320 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Ерэнгайвын Уатханыг Ховд сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрөөс томилсугай.

2. Е.Уатханыг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээний ТҮБД-5-4 дэх шатлал 938498 төгрөг /Есөн зуун гучин найман мянга дөрвөн зуун ерөн найман/-өөр цалинжуулж, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 15 хувиар үндсэн цалингаас тооцож олгохыг тус сургуулийн нягтлан бодогч Х.Бүлдиршинд зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Е.Уатханд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 00348  
D/Зак-Б/08-Да